



Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр **олборлолтын** үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит **АУДИТ**

ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ (МОНГОЛ) ХХК-ИЙН /ТОСОН-УУЛ XIX, ТАМСАГ XXI/  
ТАЛБАЙД ГАЗРЫН ТОСНЫ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ,  
ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН  
**АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 03 дугаар сарын  
03... -ны өдөр

Дугаар 445-А/3  
2023-10.

Улаанбаатар  
хот

**Ажлын зорилго:** Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулдаг Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2022 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар гүйцэтгэлийн үе шатны ажилд 2019-2022 оныг хамруулан гүйцэтгэхэд оршино.

**Ажил гүйцэтгэх хугацаа:** 2023.09.01-2023.10.01

**Байршил:** Үндэсний аудитын газар

### НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газар (цаашид “захиалагч” гэх) Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулна.

### ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Зөвлөх нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг журам, АДБОУС болон холбогдох бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбай /Дорнод аймгийн Матад, Халх гол сум/-д тус тус ажиллана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэдээллээр тайлан бичнэ. Үүнд:

1. Гэрээлэгч газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлтийг газрын тосны олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой боловсруулж, хянасан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;

2. Гэрээлэгч жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тостой холбоотой үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гаргах;
3. Гэрээлэгчийн ашиглалтын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
4. Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөгдсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
5. Орд ашиглалт, дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төсөвт өртгийг баталгаажуулах санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
6. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу олборлосон тосны хэмжээг тулгах болон гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг гэрээлэгчийн үйлдвэрлэлийн талбайд тулган баталгаажуулах;
7. Аудитын тайлангийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэхэд оролцох.

### **ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Аудитын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээ, судалгаан дахь газрын тосны мэргэжлийн техникийн нэр томьёо, агуулга, орд ашиглалт, дэд бүтэцтэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН**

Зөвлөхийн ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

Аудитын үе шат	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй үр дүн
	1. Гэрээлэгчийн газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлт нь газрын тосны олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөсөн эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	2. Гэрээлэгч жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тостой холбоотой үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	3. Гэрээлэгчийн ашиглалтын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.

<b>Гүйцэтгэлийн үе шат</b>	4. Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь олборлолтын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын талаар нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.
	5. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу олборлосон тосны хэмжээг тулгах болон гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг гэрээлэгчийн үйлдвэрлэлийн бааз дээр тулган баталгаажуулах	Гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг тулган баталгаажуулсан байна.
	6. Орд ашиглалт, дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төсөвт өртгийг баталгаажуулах санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	Гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг санхүүгийн зөвлөхийн ажлын тоо хэмжээтэй тулган баталгаажуулсан байх.
<b>Тайлагналын үе шат</b>	1. Аудитын тайлангийн төсөл боловсруулах, Аудитын зөвлөлийн хурлаар тайлангийн төсөл хэлэлцүүлэхэд оролцох.	Аудитын тайлан баталгаажсан байна.

### **ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд оролцох Зөвлөх /иргэн, хуулийн этгээд, баг байж болно/ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг гүйцэтгэхэд Үндэсний аудитын газрын аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан газрын тосны мэргэжлийн зөвлөх инженер нь ажил эхлүүлэх болон хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэн захиалагч /Үндэсний аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх явцад шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

### **ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА**

Үндэсний аудитын газар нь газрын тосны салбарт мэргэшиж, зөвлөх үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвлөхтэй ажиллах бөгөөд тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөх нь /багаар гүйцэтгэж болно/ дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

#### **Хуулийн этгээдийн хувьд:**

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг; Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Багийн ахлагч нь газрын тосны мэргэжлээр Зөвлөх инженерийн зэрэгтэй, гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үнэн бодит байдлыг хариуцаж, дүгнэлт гаргах эрх бүхий байх;
- Геологи, уул уурхай, ашигт малтмалын олон улсын чиг хандлага, газрын тосны технологийн болон үйл ажиллагааны мэдлэг мэдээлэлтэй, ажлын туршлагатай байх;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;

- Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
- Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

**Ажиллах хүчний шаардлага:**

- Газрын тосны чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Газрын тосны зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх
- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

**Баг, хувь хүний хувьд:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

**ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Газрын тосны мэргэжлийн зөвлөх инженерийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.


**Хянасан:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОТГОНБАЯР

**Боловсруулсан:**

АХЛАХ АУДИТОР



Л.НЯМТӨМӨР

АУДИТОР



Ц.БАТСҮХ  
Ж.МӨНХТУУЛ